



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 0147

Улаанбаатар хот

┌ Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 ┐
жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.1, 62.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ой, Монгол цэрэг Олон улсын Энхийг сахиулах, энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 21 жилийн ойг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, нийслэлийн Засаг даргын баталсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, дүүргийн иргэдэд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, хүүхэд багачуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх чиглэлээр олон нийтийг хамарсан ажил үйлчилгээг явуулж, төрийн батлан хамгаалах үйлчилгээг иргэдэд хүргэн ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб (хурандаа Б.Батмөнх), үйл ажиллагаа зохион байгуулах байр, техник хэрэгсэл, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган дэмжлэг үзүүлэн ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), дүүргийн Соёлын ордон (Б.Алтанцоож), Биеийн тамир Спорт хороо (Г.Тэмүүлэн), Хангай цогцолбор сургууль (Э.Соёмботат)-д тус тус үүрэг болгосугай.

2. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах дүүргийн ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсвийг хоёрдугаар хавралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 10,886,450 (арван сая найман зуун наян зургаан мянга дөрвөн зуун тавь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д үйл ажиллагааг зохион байгуулсан талаар мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Б.Батмөнх)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 02 сарын 02 -ны өдрийн 02/02 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 102 ЖИЛИЙН ОЙГ
ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн дарга:	Л.Санжийжамц	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Б.Батмөнх	Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа
	Б.Цогжавхлан	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Ш.Баасансүрэн	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	Б.Алтанцоож	Дүүргийн Соёлын ордоны захирал
	Г.Тэмүүлэн	Биеийн тамир Спорт хорооны даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Э.Соёмбобат	“Хангай” цогцолбор сургуулийн захиралын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч
	Б.Болормаа	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан
	Б.Отгонжаргал	Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын Тоо бүртгэл, дайчилгааны ахлах офицер, хошууч

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 03 сарын 02-ны өдрийн 027 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 102 ЖИЛИЙГ ОЙД ЗОРИУЛСАН
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Зохион байгуулах арга хэмжээ	Хугацаа	Төсвийн дүн
1	Монгол улсад Хурандаа Цол олгож эхэлсний 87 жилийн ойг тохиолдуулан тус дүүргээс гавъяаны амралтад суусан ахмад ажилтан “Хурандаа” цолтонуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах	03 дугаар сарын 03	1,500,000
2	“Тусгаар тогтнолын үнэ цэн” дурсамж ярилцлага, үзвэр, үйлчилгээ дүүргийн иргэд албан байгууллагын алба хаагчид сурагч нарт мэдээлэл өгөх	03 дугаар сарын 13	400,000
3	Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал, Зэвсэгт хүчний анги, байгууллагын үйл ажиллагаатай дүүргийн иргэдийн төлөөлөл Төрийн захиргааны алба хаагчдыг танилцуулах	03 дугаар сарын 13	948,000
4	“Цэрэг эрсийн түүхийн жимээр” сэдэвт Монгол цэргийн музей үзэх үйл ажиллагааг “Хангай” цогцолбор сургуулийн 5, 6 дугаар ангийн сурагчдад үзүүлнэ.	03 дугаар сарын 11	435,000
5	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдийн дундах нөхөрсөг бооцоот тэмцээн	03 дугаар сарын 14	300,000
6	Монгол Цэргийн өдрийг тохиолдуулан “Аранзал тугийн намираа” цэрэг-эх орны сэдэвт дууны бүсийн уралдаан	03 дугаар сарын 15	600,000
7	“Миний мөрөөдөл – Монгол Цэрэг” Зэвсэгт хүчний 014, 350, 353 дугаар ангийн үйл ажиллагаатай “Хангай” цогцолбор сургуулийн ахлах ангийн сурагчдад танилцуулах	03 дугаар сарын 15	1,002,250
8	Багахангай дүүрэг, Баян сум дахь Төрийн цэргийн болон хууль сахиулах анги байгууллагуудын Марш тактикийн тусгай бэлтгэлийн аврага тасаг шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	03 дугаар сарын 16	1,376,000
9	Сурталчилгааны анонс бэлтгэл ажлын шатахууны зардал	03 дугаар сарын 02	725,200

10	Монгол Цэргийн нэгдсэн холбоо, Бага дарга нарын холбооноос зохион байгуулах Цэргийн андууд уулзалтад дүүргийн иргэд бэлтгэл түрүүч, бага дарга нарыг сонгон оролцуулах, Үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж оролцоно	3-р сарын 14-нд	500,000
11	“Бүүвэйн дуутай Цэргийн бүсгүйчүүд” Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад ажилллаж байгаа, гавъяаны амралтад гарсан эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ	3 сар 17-нд	1,520,000
12	Зэвсэгт хүчин Хилийн болон Дотоодын цэргийн анги байгууллагад алба хааж байгаа дайчдыг эргэх тэдний санал сэтгэгдлийн сонсох ажлыг зохион байгуулж тэдний алба хааж байгаа анги байгууллагатай эцэг эхийн төлөөллийг танилцуулах	3 дугаар сард	1,580,000
НИЙТ			10,886,450